



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгал орчин аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/28/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019
Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.20 № 106

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Байгаль орчин аялал жуулчлалын газар нь Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 77,750.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг зардал хооронд зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам", 2021 оны 190 дүгээр тушаалаар "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" тус тус зөрчсөн бөгөөд аудитын *тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Архангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь тайлант онд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 18 арга

хэмжээнд 574.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 486.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын төсөв захирагч нь Архангай аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн б/41 тоот захирамжаар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр, мөн төрийн захиргааны нэр бүхий 9 албан хаагч түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна. Сүүлийн 3 жилийн дотор байгууллагын удирдлага 4 удаа солигдсон байгаа нь тус байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, санхүүгийн төсвийн удирдлагад эрсдэл үүсэх магадлалтай байна.

Бусад асуудлын хэсэг

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж, аймгийн Засаг даргаас 87.6 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,429,834.09	1,526,150.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,429,834.09	1,526,150.00
351	Түүхий эд материал	43,949,446.09	-
35110	Тусгай зориулалттай материал	43,949,446.09	-
354	Хангамжийн материал	12,480,388.00	1,526,150.00
35420	Аж ахуйн материал	3,616,150.00	1,526,150.00
35470	Бусад хангамжийн материал	8,864,238.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	217,593,603.64	151,342,597.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	217,593,603.64	151,342,597.14
392	Биет хөрөнгө	206,073,603.64	140,062,597.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,122,629.40	21,122,629.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,872,913.40)	(14,089,249.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,193,615.00	127,193,615.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(72,596,948.66)	(91,193,615.42)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,343,675.00	34,725,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,902,335.76)	(18,704,277.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,612,110.85	12,376,864.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,275,833.99)	(10,805,678.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	167,960,483.00	98,924,334.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(49,521,877.80)	(19,498,924.66)
39217	Ном	11,000.00	11,000.00
393	Биет бус хөрөнгө	11,520,000.00	11,280,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(780,000.00)	(1,020,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	274,023,437.73	152,868,747.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	274,023,437.73	152,868,747.14
51	Засгийн газрын хувь оролцоо	274,023,437.73	152,868,747.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	210,736,397.50	210,736,397.50
512	Хуримтлагдсан үр дүн	56,686,326.95	(64,468,363.64)
51210	Өмнөх үеийн үр дүн	56,686,326.95	56,686,326.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	(121,154,690.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,600,713.28	6,600,713.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	274,023,437.73	152,868,747.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,003,292,400.00	1,220,249,134.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,815,500.00	11,685,684.00
120	Нийтлэг татварын бус орлого	49,815,500.00	11,685,684.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		11,510,684.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан - Үндсэн хөрөнгө	49,815,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	953,476,900.00	1,208,563,450.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,392,400.00	8,657,750.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,657,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,392,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	931,084,500.00	1,199,905,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	931,084,500.00	1,199,905,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	942,756,196.49	1,245,561,862.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,756,196.49	1,245,561,862.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,531,833.58	1,162,093,032.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444,525,430.00	469,197,320.10
210101	Үндсэн цалин	320,944,211.00	378,781,038.82
210102	Нэмэгдэл	106,165,630.00	47,693,584.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,415,589.00	31,375,500.00
210104	Урамшуулал	-	11,347,197.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,697,795.09	58,557,122.64
210201	Тэтгэврийн даатгал	39,916,777.89	40,044,160.41
210202	Тэтгэмжийн даатгал	4,445,254.30	4,697,511.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,556,203.92	3,758,009.98
210204	Ажилгүйдлийн даатгал	889,050.38	914,312.36
210205	Эрүүл мэндийн даатгал	8,890,508.60	9,143,128.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,505,760.00	10,116,949.06
210301	Гэрэл, цахилгаан	135,365.00	509,818.34
210302	Түлш, халаалт	8,873,088.00	8,873,086.72
210303	Цэвэр, бохир ус	1,497,307.00	734,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,867,188.83	68,629,734.09
210401	Бичиг хэрэг	1,536,280.00	2,152,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,885,560.00	8,716,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,480,390.00	1,443,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	291,100.00	1,107,900.00
210408	Бараа материал акталсны зардал	5,673,858.83	55,013,684.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	501,500.00	3,174,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	330,000.00	2,285,000.00
210604	Урсгал засвар	171,500.00	889,920.00
2107	Томиллолт, зочны зардал	2,088,000.00	726,000.00
210702	Дотоод албан томиллолт	2,088,000.00	726,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,845,006.00	483,738,509.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,830,350.00	483,213,797.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,700.00	234,056.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	28,956.00	40,956.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,000.00	66,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,501,153.66	67,952,477.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,392,400.00	8,282,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,108,753.66	59,669,727.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,224,362.91	83,468,829.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,213,179.00	65,256,634.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,615,000.00	4,845,534.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,098,800.00	56,297,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,499,379.00	4,113,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	175,011,183.91	18,212,195.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	175,011,183.91	18,212,195.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	60,536,203.51	(25,312,728.05)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	95,841,962.54
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	95,841,962.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(95,841,962.54)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	60,536,203.51	(121,154,690.59)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	953,476,900.00	1,208,738,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	953,476,900.00	1,208,563,450.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,392,400.00	8,657,750.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,657,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,392,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	931,084,500.00	1,199,905,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	931,084,500.00	1,199,905,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	888,924,053.00	1,130,988,450.00

Архангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	888,924,053.00	1,130,988,450.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	678,699,690.09	1,047,519,620.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,820,899.00	469,197,320.10
210101	Үндсэн цалин	322,239,680.00	378,781,038.82
210102	Нэмэгдэл	106,165,630.00	47,693,584.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,415,589.00	31,375,500.00
210104	Урамшуулал	-	11,347,197.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,697,795.09	58,557,122.64
210201	Тэтгэврийн даатгал	39,916,777.89	40,044,160.41
210202	Тэтгэмжийн даатгал	4,445,254.30	4,697,511.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,556,203.92	3,758,009.98
210204	Ажилгүйдлийн даатгал	889,050.38	914,312.36
210205	Эрүүл мэндийн даатгал	8,890,508.60	9,143,128.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,505,760.00	10,116,949.06
210301	Гэрэл, цахилгаан	135,365.00	509,818.34
210302	Түлш, халаалт	8,873,088.00	8,873,086.72
210303	Цэвэр, бохир ус	1,497,307.00	734,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,193,330.00	13,616,050.00
210401	Бичиг хэрэг	1,536,280.00	2,152,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,885,560.00	8,716,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,480,390.00	1,443,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	291,100.00	1,107,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	851,500.00	3,284,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	680,000.00	2,285,000.00
210604	Урсгал засвар	171,500.00	999,920.00
2107	Томилолт, зочны зардал	2,088,000.00	726,000.00
210702	Дотоод албан томилолт	2,088,000.00	726,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,150,006.00	483,738,509.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,135,350.00	483,213,797.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,700.00	234,056.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	28,956.00	40,956.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,000.00	66,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,392,400.00	8,282,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,392,400.00	8,282,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,224,362.91	83,468,829.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,213,179.00	65,256,634.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,615,000.00	4,845,534.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,098,800.00	56,297,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,499,379.00	4,113,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	175,011,183.91	18,212,195.20

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	175,011,183.91	18,212,195.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	64,552,847.00	77,750,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	64,552,847.00	77,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,552,847.00	77,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	64,552,847.00	77,750,000.00
222001	Тоног төхөөрөмж	64,552,847.00	77,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(64,552,847.00)	(77,750,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	7,422,289.40	224,759,400.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	7,422,289.40	224,759,400.18
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	49,264,037.55	49,264,037.55
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	56,686,326.95	274,023,437.73
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	56,686,326.95	274,023,437.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	56,686,326.95	274,023,437.73
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(121,154,690.59)	(121,154,690.59)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	(64,468,363.64)	152,868,747.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1199905700.00	1181868504.80	18037195.20	98.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1199905700.00	1181868504.80	18037195.20	98.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1134644600.00	1116611870.80	18032729.20	98.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472092700.00	469197320.10	2895379.90	99.39
210101	Үндсэн цалин	367530800.00	378781038.82	-11250238.82	103.06
210102	Нэмэгдэл	69022400.00	47693584.28	21328815.72	69.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29258500.00	31375500.00	-2117000.00	107.24
210104	Урамшуулал	0.00	11347197.00	-11347197.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	6281000.00	0.00	6281000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59011600.00	58557122.64	454477.36	99.23
210201	Тэтгэврийн даатгал	40127900.00	40044160.41	83739.59	99.79
210202	Тэтгэмжийн даатгал	4720900.00	4697511.87	23388.13	99.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3776700.00	3758009.98	18690.02	99.51
210204	Ажилгүйдлийн даатгал	944200.00	914312.36	29887.64	96.83
210205	Эрүүл мэндийн даатгал	9441900.00	9143128.02	298771.98	96.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10153900.00	10116949.06	36950.94	99.64
210301	Гэрэл, цахилгаан	659000.00	509818.34	149181.66	77.36
210302	Түлш, халаалт	8910000.00	8873086.72	36913.28	99.59
210303	Цэвэр, бохир ус	584900.00	734044.00	-149144.00	125.50
2104	Хангамж, бараа материалын зардал	13267600.00	13241050.00	26550.00	99.80
210401	Бичиг хэрэг	2591300.00	1777400.00	813900.00	68.59
210402	Тээвэр, шатахуун	7078000.00	8716900.00	-1638900.00	123.15
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,476,800.00	1,443,850.00	32950.00	97.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	195,000.00	5000.00	97.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,921,500.00	1,107,900.00	813600.00	57.66
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,318,000.00	3,284,920.00	33080.00	99.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,318,000.00	2,285,000.00	33000.00	98.58
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,920.00	80.00	99.99
2107	Томилолт, зочны зардал	1,568,300.00	726,000.00	842300.00	46.29
210702	Дотоод албан томилолт	1,568,300.00	726,000.00	842300.00	46.29

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,232,500.00	561,488,509.00	13743991.00	97.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	574,658,300.00	560,963,797.00	13694503.00	97.62
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	257,500.00	234,056.00	23444.00	90.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	33,000.00	17000.00	66.00
210807	Газрын төлбөр	50,000.00	40,956.00	9044.00	81.91
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	66,700.00	66,700.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,261,100.00	65,256,634.00	4466.00	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,261,100.00	65,256,634.00	4466.00	99.99
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,850,000.00	4,845,534.00	4466.00	99.91
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,297,400.00	56,297,400.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,113,700.00	4,113,700.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,199,905,700.00	1,181,693,504.80	18212195.20	98.48
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,199,905,700.00	1,181,693,504.80	18212195.20	98.48
132001	Орон нутгийн төсвөөс	1,199,905,700.00	1,181,693,504.80	18212195.20	98.48
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	49.00	49.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,657,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,657,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,657,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	375,000.00
210801	Бичиг хэрэг	375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,750.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,657,750.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,657,750.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,657,750.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, харин залруулагдаагүй нийт 82,595.5 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 82,595.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүллээ.

5.2 Албан шаардлага

5.2.1 Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 77,750.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаал, 2018 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн 134 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.2 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д хамаарахгүй 6 арга хэмжээнд 185,000.0 мянган төгрөгийн төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 156,988.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.5 дахь заалт, ЗГ-ын 2022 оны 2-р тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5-т “Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ”, 3.6-т “Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр, энэ журмын 3.5.6, 3.5.7, 3.5.8-д зааснаас гадна тухайн сум, дүүргийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ”, 3.7-д “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох, ЗГ-ын 2022 оны 2-р тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу төлөвлөх, зарцуулахад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2.3 Тайлант онд БОАЖГ-ын дарга болон мэргэжилтэн, байгаль хамгаалагч нийлсэн нийт 10 албан хаагч түр орлон гүйцэтгэгчээр 2021-2022 онуудад томилогдон ажиллаж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно”, 26 дугаар зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

26.1-т "Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно", 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.4 Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн 2022.08.30-ны өдрийн 22010064/04 тоот мэдэгдэх хуудсаар Архангай аймгийн Засаг даргад Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021.11.07-ны өдрийн 044 дугаартай шүүгчийн захирамжийн дагуу сум дундын ойн ангийн дарга Ч.Лувсандагвад ажилгүй байсан хугацааны 6 сарын цалин болох 4,845.5 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

Дээрх шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БОАЖГ	4	82,595.5	-	-	4	82,595.5	-	-	-	-	-	-